

**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 09 сарын 05 өдөр

Дугаар А/39

Өлгий

Г 7

Мэргэжлийн үйл ажиллагаа явуулах
тусгай зөвшөөрөл олгох, хүсэлтийг
дэмжих тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2, 19.3, 19.5, Зөвшөөрлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 5.3, 5.5, 8.1 дүгээр зүйлийн 13 дугаар жагсаалтын 13.8, 13.9, 13.10, 13.11, 13.12, 13.14, 13.15, 13.19, 13.20 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийн комиссын 2023 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах, гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт оруулах, зөвшөөрөл нь дэмжигдсэн байгууллагуудын жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Эрүүл мэндийн тухай хууль, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль, сумдын ЭМТ, клиник, эмийн санд тавигдах стандарт шаардлагуудыг ханган ажиллахыг тусгай зөвшөөрөл авсан эрүүл мэндийн байгууллагуудад даалгасугай.

3. Мэргэжлийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл хүссэн эмийн сан, клиникүүдийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход баримтлах чиглэлийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Тусгай зөвшөөрөл олгох комиссын гишүүдэд үүрэг болгосугай.

ДАРГА



Н.САКЕН

Эрүүл мэндийн газрын даргын
2023 оны 09 сарын 05 өдрийн /А/ 34 тоот
тушаалын үндсэн дээр хавсралт

ХӨӨМД19

НЭГ. МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ НЬ СУНГАГДСАН
БАЙГУУЛЛАГУУД :

№	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Хугацаа	Хүчинтэй хугацаа
1	“Бейсшипа” ХХК-ийн “Бейсшипа” мэс засал, дотрын ортой эмнэлэг	Дотор, мэс заслын ортой эмнэлэг	5 жилээр	2028.08.31
2	“Ушкын” ХХК-ийн “Ушкын” эмийн сан	Эмийн сан	5 жилээр	2028.08.17

ХОЁР. МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛД НЭМЭЛТ
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ:

1. “Бейс-Шипа” эмнэлэгт уламжлалтын тусламж, үйлчилгээ нэмэх
2. “Фатиха” дотор, уламжлалтын ортой эмнэлгийн хүүхдийн тусламж, үйлчилгээг хасах

ГУРАВ. МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ НЬ
ДЭМЖИГДСЭН БАЙГУУЛЛАГА:

1. “Хүйтэн салаа” ХХК-ийн “Таван салаа” эмийн сан